



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БОЛОН МАНДАЛ
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН
НЭР ДЭВШИГЧ ГУНГААСАМБУУГИЙН
ЖАРГАЛ ТАНАА

2020.09.03 № САА-2020/06-12-69
танай _____-ны № _____-т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн болон Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Гунгаасамбууугийн Жаргалын мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сэлэнгэ аймгийн болон Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Г.Жаргал нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050” холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Г.Жаргалын Сэлэнгэ аймгийн болон Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Г.Жаргалын мөрийн хөтөлбөр /...5... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн болон Мандал сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БОЛОН МАНДАЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХҮРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ГУНГААСАМБУУГИЙН ЖАРГАЛЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

НЭГ. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГО

1.1 Эрүүл мэндийн бодлого

- 1.1.1 Иргэдэд хүргэх эрүүл мэндийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 1.1.2 Орон нутагт өндөр хүчин чадалтай нарийн мэргэжлийн лаборатори байгуулах, бусад нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг сайжруулах санал, санаачилга гаргаж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 1.1.3 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өрхийн эмнэлгийн эмч нарыг чадваржуулахад анхаарч ажиллана.

1.2 Боловсролын бодлого


- 1.2.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримтална.
- 1.2.2 Дутуу баригдсан цэцэрлэгийн барилгыг дуусгах, цэцэрлэгүүдийг өргөтгөх, гэр цэцэрлэг ажиллуулахад шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлүүлэх ажлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 1.2.3 Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын сурхадлын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр ажиллана.
- 1.2.4 Орон нутагт эрэлт хэрэгцээ ихтэй мэргэжлээр гадаад, дотоодын их, дээд сургуульд оюутан сургаж бэлтгэх, боловсон хүчнийг давтан болон мэргэшүүлэх сургалтад хамруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

1.3 Соёл, спорт, аялал жуулчлалын бодлого

- 1.3.1 Иргэдийн дунд урлаг спортын наадмуудыг үе шаттайгаар зохион байгуулж, ардын авьяастнуудыг тодруулах ажлыг санаачлан, уламжлал болгон зохион байгуулна.
- 1.3.2 Хүүхэд багачуудыг мэргэжлийн урлагийн байгууллагуудын дэргэдэх төрөл бүрийн дугуйлан секцэд хамрагдаж, авьяас чадвараа хөгжүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.
- 1.3.3 Спортын клуб холбоодын үйл ажиллагааг дэмжин, хүүхэд залуучуудыг спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 1.3.4 Стандартын шаардлагад нийцсэн хөл бөмбөгийн талбай байгуулах санаачилга гарган холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 1.3.5 Нийтийн номын сангийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 1.3.6 Байгалийн болон түүхийн дурсгалт газруудад тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх санал санаачилга гаргаж, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.
- 1.3.7 Орон нутгийн онцлог, түүх соёлын дурсгалыг хадгалж, олны хүртээл болгох зорилгоор орон нутаг судлах музей байгуулах ажлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.

1.4. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого

- 1.4.1 Ажилгүй иргэдийг мэргэжил олгох болон давтан сургалтад хамруулан мэргэжлийн зөрүүгээс үүсэх ажилгүйдлийг бууруулах чиглэлээр ажиллана.
- 1.4.2 Малчид, албан бус секторт хөдөлмөр эрхлэгчид, ажилгүй иргэд жижиг аж ахуй эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 1.4.3 Ахмадын сувиллын орчин нөхцөлийг сайжруулах замаар ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх санал, санаачилга гарган, хэрэгжүүлнэ.
- 1.4.4 Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор багийн иргэдийн дунд хуримтлалын сан байгуулах ажлыг зохион байгуулна.



ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1 Хөдөө аж ахуйн бодлого

- 2.1.1 Төмс, хүнсний ногоо тариалагчдыг хоршоо бүлгийн зохион байгуулалтад оруулж, тарьсан ногоог хэрэглэгчдэд хүргэх, борлуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал, санаачилгыг дэмжинэ.
- 2.1.2 Эрдэмтэн судлаачидтай хамтран фермерийн аж ахуй эрхлэгч, төмс хүнсний ногоо тариалагч иргэдийн мэдлэг, дадлагыг дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 2.1.3 Хүлэмж, зоорины аж ахуй хөгжүүлж, тариалах ургамлын нэр төрлийг олшуулан үрийн бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.1.4 Газар тариалангийн зориулалтаар ашиглаж байгаа талбайн ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.
- 2.1.5 Малчдыг эрчимжсэн мал аж ахуй эрхлэх болон тэжээлийн ургамал тариалах, боловсруулах арга аргачлалд сургах сургалтыг мэргэжлийн байгууллагуудаар үе шаттайгаар зохион байгуулаах арга хэмжээ авна.
- 2.1.6 Малын төрөл хоорондын зохистой харьцааг бүрдүүлж, цэвэр эрлийз малын тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- 2.1.7 Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулна.

2.2 Үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний бодлого

- 2.2.1 Хүнсний ногоо боловсруулах, савлах үйлдвэр байгуулах иргэдийн санал санаачилгыг дэмжин, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.
- 2.2.2 Хүн амын хүнсний хангамж, түүний аюулгүй байдалд тавих хяналтыг тогтмолжуулах, зориулалтын лабораторитой болох асуудлыг дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.2.3 Чацааргана, жимс жимсгэнэ, зөгийн аж ахуй зэрэг мал ургамлын гаралтай түүхий эдийг түшиглэсэн анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.
- 2.2.4 Аж үйлдвэр байгуулах аж ахуйн нэгж байгууллагын саналыг дэмжиж, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр ажиллана.
- 2.2.5 Суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид шаардлагатай түүхий эд болон бусад материалыг орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдээс хангах ажлыг дэмжин, хамтарч ажиллана.
- 2.2.6 Тэжээлийн үйлдвэр эрхлэх хүсэлтэй иргэдийг дэмжинэ.
- 2.2.7 Мал амьтны ялгадсыг ашиглан бордооны жижиг үйлдвэр байгуулах, био бордоо үйлдвэрлэх, зах зээлд борлуулах иргэдийн санал, санаачилгыг дэмжиж, холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.
- 2.2.8 Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, борлуулах, малчдын бүлэг, хоршоог дэмжин, сүү боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг байгуулах санал санаачилгыг дэмжин, хамтарч ажиллана.

2.3 Дэд бүтэц

- 2.3.1 Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулахад шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусгуулах санал, санаачилга гарган шийдвэрлүүлнэ.
- 2.3.2 Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор утаагүй түлшний хэрэглээг нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 2.3.2 Зөөврийн ус хэрэглэж буй иргэдийг гүний худагтай болгох асуудлыг холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлүүлнэ.
- 2.3.3 Хөдөөгийн зам, гэр хорооллын гудамжны замуудыг засварлахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусгуулахаар уламжилж, хэрэгжүүлэх арга хэмжээ авна.
- 2.3.4 Иргэдийн аюулгүй орчинд зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орчин үеийн шинэлэг загвар бүхий, эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх газруудыг судлан, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

2.3.5 "Тохилог, цэвэр сайхан орчин"-д амьдарцгаая" уриалга гаргаж иргэд, байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлнэ.

2.3.6 Өрх бүрийг эрүүл ахуйн стандартад нийцсэн бие засах газартай болгох талаарх судалгааг гарган, олон улсын болон Азийн хөгжлийн санд санал боловсруулан уламжилж, хэрэгжүүлнэ.

2.3.7 Нийтийн тээврийн үйлчилгээг тогтмолжуулж, бага оврын автобусаар иргэдэд үйлчлэх асуудлыг орон нутгийн засаг захиргааны байгууллагад санал оруулж, хамтран шийдвэрлэнэ. МЮА0065 9055436

2.3.8 Сумын төвийн төвлөрсөн дулаан хангамж, цэвэр бохир усны шугам сүлжээ байгуулах ажлыг үргэлжлүүлэх ажлын санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

2.3.9 Эрчим хүчний дутагдалтай айл өрх, байгууллагуудыг судлан дэд станцууд нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

2.3.10 Хүүхэд залуучуудын соёл спортын цогцолбор төвийн барилгыг үргэлжлүүлэх асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлнэ.

2.3.11 Сумын төв, Хэрх, Түнхэл, Тарни багийн доторх авто замыг сайжруулах, асфальтан замтай болгох ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр санал, санаачилга гаргаж, хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

2.3.12 Иргэд эрүүл агаарт чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор цэцэрлэгт хүрээлэнгүүдийг тохижуулах, тоглоомын талбайг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

2.3.13. Сумын төв, Хэрх, Түнхэл, Тарни багийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг судлан, холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.

2.4 Байгаль орчин, аялал жуулчлалын талаар хэрэгжүүлэх бодлого

2.4.1 Хот, тосгод, багийн нутаг дэвсгэрийн уур амьсгалыг зөөллөх, тоосжилтыг бууруулах, хотын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг гудамж, талбай, хашаандаа мод тарих ажлыг зохион байгуулна.

2.4.2 Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

2.4.3 Бичил уурхайгаар алт олборлож байгаа иргэдийн үйл ажиллагаа явуулсан газруудад нөхөн сэргээлт хийх ажилд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлуудыг холбогдох байгууллагад уламжилж арилгуулна.

2.4.4. Зөгийн аж ахуй хөгжүүлэх иргэдийн санал санаачилгыг дэмжин ажиллана.

2.4.5. Хараагийн их Ноён уулыг төрийн тахилгат болгохоор Сэлэнгэ аймгийн ИТХ-д өргөн барьсан ажлаа үргэлжлүүлж, шийдвэрлүүлэх чиглэлээр ажиллана.

ГУРАВ. ТӨРИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГО

3.1 Төрийн ажил үйлчилгээний талаар

3.1.1 ЗДТГ-т "Хөтөч" үйлчилгээг нэвтрүүлж, иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ хүргүүлэх арга хэмжээ авна.

3.1.2 Төрийн албаны ажил үйлчилгээг хурдан шуурхай болгох зорилгоор эд хөрөнгийн бүртгэгчийн орон тоог нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.

3.1.3 Мэдээлэл технологи, цахим орчныг ашиглан цаасаар үйлддэг шат дамжлагыг бууруулах бодлого баримтална.

3.1.5 Иргэдийн газар өмчлөлийн асуудлыг судлан, өмчлөлийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

3.1.6 Төрийн албан хаагчдын ажлын байрны нөхцөлийг сайжруулах асуудлыг сумын ЗДТГ-тай хамтран шийдвэрлэнэ.

3.1.7 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хотын төвийн байгууллага, авто замуудыг камержуулах газруудыг судлан, хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

3.1.8 Түнхэл тосгонд суурин ажиллах нотариатчийн асуудлыг холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлүүлнэ.

Хөтөлбөр боловсруулсан:

Жаргал

Г.Жаргал